




АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТ

I. ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Албан тушаалын тодорхойлолтыг боловсруулсан үндэслэл:

☐ Төрийн албаны тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбогдуулан шинэчлэн боловсруулсан

☒ Хууль тогтоомжоор байгууллагын чиг үүрэгт өөрчлөлт орсон

Холбогдох хууль тогтоомжийн нэр, огноо:

Дагаж мөрдөх огноо:

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан огноо:

Байгууллагын нэр:

Газар зохион байгуулалт, геодези, зураг
зүйн газар

Нэгжийн нэр:

Геодези, зураг зүйн хэлтэс

Албан тушаалын нэр:

Газар зүйн нэрийн мэдээллийн сан
хариуцсан мэргэжилтэн

Албан тушаалын ангилал, зэрэглэл:

Дэс түшмэл, ТЗ-7

Ажлын цаг:

Ажлын өдрийн 8 цаг

Ажлын байрны албан ёсны байршил:

15170, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Барилгачдын талбай 3

Хөдөлмөрийн нөхцөл:

Хэвийн

Онцгой нөхцөл:

Хамаарахгүй

II. АЛБАН ТУШААЛЫН ЗОРИЛГО, ЗОРИЛТ, ЧИГ ҮҮРЭГ


Албан тушаалын зорилго:

Монгол Улсын нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд хамаарах газар зүйн нэрийг тодруулах, мэдээллийн сан бүрдүүлэх, хэрэглэгчдийг мэдээллээр хангах чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг нэгжийн даргын өмнө хариуцна.

Албан тушаалын зорилт:

- 1.Монгол Улсын хууль болон Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, үндэсний хэмжээний урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөг боловсруулахад газар зүйн нэрийн чиглэлээр санал өгөх, хэрэгжилтийг хангах, холбогдох хууль тогтоомж болон тэдгээрт нийцүүлэн гарах хэм хэмжээний акт, бусад баримт бичгийг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх чиг үүргийн хүрээнд гүйцэтгэлийн үр дүнг газар болон хэлтсийн даргын өмнө хариуцна;
- 2.Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд газар зүйн нэрийн тодруулалтын ажлыг зохион байгуулах, газар зүйн нэрийг батлуулах ажлыг зохион байгуулах;
- 3.Газар зүйн нэрийн мэдээллийн системийг хөгжүүлэх, газар зүйн нэрийн мэдээллийн санг шинэчлэх, мэдээллийн сангийн хэвийн үйл ажиллагааг хангах, хэрэглэгчийг газар зүйн нэрийн мэдээллээр хангах, олон нийтэд үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлж, таниулан сурталчилах ажлыг зохион байгуулах;
- 4.Нэгжийн дотоод үйл ажиллагаанд оролцох, холбогдох хууль тогтоомжид заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэх, тайлагнах.

Зорилт	Албан тушаалын гүйцэтгэх чиг үүрэг	Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт	Хариуцлага, оролцооны хэлбэр Туслах-Т, Гүйцэтгэх-Г, Хянах-Х, Шийдвэрлэх-Ш
1 дүгээр зорилтын хүрээнд	1.Монгол Улсын хууль болон Монгол Улсын хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичиг, Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр боловсруулахад газар зүйн нэрийн чиглэлээр санал өгөх, хэрэгжүүлэх;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	Г
	2.Салбарын урт, дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд газар зүйн нэрийн талаар тусгах арга хэмжээг боловсруулах, санал өгөх, хэрэгжүүлэх;	Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан байх;	Г
	3.Байгууллагын дунд хугацааны стратеги төлөвлөгөөнд газар зүйн нэрийн чиглэлийн арга хэмжээг боловсруулж, тусгах, хэрэгжилтийг хангах;	Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан байх;	Г
	4.Геоземи, зураг зүйн тухай хууль болон тэдгээрт нийцүүлэн гарах хэм хэмжээний акт, бусад баримт бичгийг боловсруулж, батлуулах, хэрэгжүүлэх;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	Г
	5.Газар зүйн нэрийн чиглэлээр хийгдэх төсөл, хөтөлбөрийг боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	Төлөвлөлт нь төрийн бодлого, хөтөлбөртэй уялдсан, судалгаа, дүгнэлт бодитой	Г



		хийгдсэн байх.	
2 дугаар зорилтын хүрээнд	1.Монгол Улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хийгдэх газар зүйн нэрийн ажлыг төлөвлөх, төсөв тооцоо гаргах, техник эдийн засгийн үндэслэл боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Геодези, зураг зүйн салбарын бодлого, төлөвлөгөөтэй уялдсан ажил, үйлчилгээ хэрэгжсэн байх;	Г
	2.Газар зүйн нэрийн тодруулалтын ажлын даалгаврыг хамтран боловсруулах, батлуулах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх;	Г
	3.Газар зүйн нэрийн тодруулалтын ажлын хэрэгжилтэд хяналт тавих, үр дүнг дүгнэх ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх;	Г
	4.Газар зүйн нэрийг батлуулах санал боловсруулах, батлуулах, хэрэглээнд гаргах;	Баталгаажсан газар зүйн нэрийг ашиглах нөхцөл бүрдсэн байх;	Г
	5.Монгол орны газар зүйн нэрийн тодруулалт, шинэчлэлт, өөрчлөлтийг цахимжуулах ажлыг зохион байгуулах;	Монгол орны газар зүйн нэрийг тодотгон тогтоож, батлуулсан байх;	Г
	6.Газар зүйн нэрийн чиглэлээр хийгдсэн ажлыг шалгаж, дүгнэлт гаргах, геодези, зураг зүйн улсын нэгдсэн санд төвлөрүүлэх;	Улсын төсвөөр хийгдэж буй ажлууд шалгагдсан, улсын нэгдсэн санд хүлээлгэж бүртгэгдсэн байх;	Г
	7.Газар зүйн нэрийн чиглэлээр олон улсын төсөл, хөтөлбөр, гэрээ, хэлэлцээр, санамж бичиг байгуулах санал боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах.	Төсөл, хөтөлбөрийн хэмжээнд хийгдэж буй үйл ажиллагаа давхардахгүй, хууль тогтоомжийн хүрээнд хэрэгжсэн байх.	Г
3 дугаар зорилтын хүрээнд	1.Газар зүйн нэрийн мэдээллийн системийг байгуулах, хөгжүүлэх санал боловсруулах, хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах;	Газар зүйн нэрийн мэдээллийн системийн хөгжүүлэлт хийгдэж, хэрэглэгчдийг мэдээллээр хангах боломж бүрдсэн байх;	Г
	2.Газар зүйн нэрийн гео орон зайн мэдээллийн сан бүрдүүлэх, мэдээллийг	Орон зайн мэдээллийн	Г



	шинэчлэх, иргэн, хуулийн этгээдэд нэрийн мэдээллээр үйлчилгээ үзүүлэх нөхцлийг бүрдүүлэх;	сангийн шаардлагыг хангасан байх;	
	3.Газар зүйн нэрийн тодруулалтын ажлын үр дүнг цахимжуулах ажлыг зохион байгуулах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх;	Г
	4.Газар зүйн үнэн зөв нэрийг хэрэглүүлэх, өвлүүлэх, олон нийтэд таниулан сурталчлах, мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах;	Олон нийтийг зөв, бодитой мэдээллээр хангасан байх;	Г
	5.Газар зүйн нэрийн зураг зохиох, баталгаажуулах, нэрийн лавлах, толь боловсруулах, нэрийн жагсаалт гаргах;	Холбогдох хууль тогтоомжид нийцсэн байх;	Г
	6.Газар зүйн нэрийн мэдээллийн сангийн талаарх судалгаа, шинжилгээний ажлыг эрхлэх, орчин үеийн техник, технологийн дэвшлийг нэвтрүүлэх, туршлага судлах;	Судалгаа, дүгнэлт бодитой хийгдсэн байх;	Г
	7.Улсын хэмжээнд газар зүйн нэрийн чиглэлээр хийгдсэн судалгаа, хэрэгжиж буй төсөл, хөтөлбөр, хууль, тогтоомжийн хэрэгжилт, зохион байгуулсан арга хэмжээ, хүрсэн үр дүнгийн талаарх мэдээллээр ханган ажиллах.	Зөв бодитой мэдээ, мэдээллээр хангасан байх.	Г
4 дүгээр зорилтын хүрээнд	1.Нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцох;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт хангагдсан байх;	Г
	2.Байгууллагын стратеги болон гүйцэтгэлийн төлөвлөгөөнд хариуцсан ажлын чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлын тооцоо, төсөвт тусгуулах санал боловсруулах, хэрэгжилтийг хангах;	Тооцоо, судалгааг нь үнэн зөв гаргасан байх;	Г
	3.Гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулах, батлуулах, хэрэгжүүлэх;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	Г
	4.Гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлтийг сар, улирал, хагас жилээр гаргаж нэгжийн даргад тайлагнах;	Гүйцэтгэлийн төлөвлөгөө, түүний хэрэгжилт хангагдсан байх;	Г
	5.Үнэлгээний хороо болон ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллах;	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх;	Г
	6.Байгууллагын даргын дэргэдэх зөвлөлийн хурал, удирдах ажилтны	Үүрэг даалгавар цаг хугацаандаа	Г



	шуурхай зөвлөгөөн, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврыг хэрэгжүүлж, цаг үеийн шаардлагаар гарсан ажлуудын биелэлтийг хангах;	бүрэн хэрэгжсэн байх;	
	7.Байгууллагын дотоод дүрэм, журам, Төрийн албан хаагчийн ёс зүйн дүрмийг мөрдлөг болгон ажиллах, төрийн захиргааны манлайллыг хэрэгжүүлэх;	Дүрэм, журам ёс зүйн хэм хэмжээнд заасан манлайлал бий болсон байх;	Г
	8.Хариуцсан үйл ажиллагааны хүрээнд бүрдүүлсэн баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн, хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу архивт хүлээлгэн өгөх;	Архивын ажлын үндсэн зааварт нийцсэн байх;	Г
	9.Байгууллагын болон нэгжийн өдөр тутмын үйл ажиллагаа, хурал, сургалт, олон нийтийн арга хэмжээнд оролцох;	Хамрагдсан хурал, уулзалт, удирдлагаас өгсөн үүрэг даалгаврын биелэлт хангагдсан байх;	Г
	10.Геодези, зураг зүйн чиглэлээр мэргэжлийн боловсон хүчний сургалтын эрэлт хэрэгцээг тодорхойлох, төлөвлөгөөнд санал өгөх, хүний нөөцийг чадавхижуулах, мэргэшүүлэх, давтан сургах;	Салбарын мэргэжилтнүүдийн мэргэжлийн чадавхи дээшилсэн байх;	Г
	11.Геодези, зураг зүйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй байгууллага болон бусад байгууллагыг мэргэжил, арга зүйн зөвлөгөөгөөр хангах;	Бусад салбар геодези, зураг зүйн чиглэлээр ойлголт мэдлэгтэй болсон байх;	Г
	12.Аймаг, нийслэлийн газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын үйл ажиллагаа болон гүйцэтгэлийн тайлан, хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрт газар зүйн нэрийн чиглэлээр хяналт тавих үнэлгээ өгөх, мэргэжил, арга зүйгээр хангаж ажиллах.	Холбогдох хууль тогтоомжтой нийцсэн байх.	Г, Х

III.АЛБАН ТУШААЛД ТАВИГДАХ ТУСГАЙ ШААРДЛАГА:

Боловсрол	Бакалавр ба түүнээс дээш боловсролын зэрэгтэй.
Мэргэжил	Дэлхий судлал (053201) (геодезийн инженер, инженер геодези, сансрын геодези-астрономи, агаарын зураглал, зураг зүй).
Мэргэшил	-
Туршлага	Туслах түшмэлийн албан тушаалд ажилласан бол давуу тал болно.



Ур чадвар	Дүн шинжилгээ хийх	- Мэдээллийн үнэн, бодит байдлыг шалган нягтлах; - нарийн төвөгтэй мэдээллийг шинжилж, шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг тодруулах; - байгууллагын үйл ажиллагаанд учирч болзошгүй эрсдэлийг илрүүлэх; - албан ажлын хэрэгцээнд шаардагдах мэдээллийг нэгтгэн дүгнэх, санал зөвлөмж боловсруулах; - мэдээлэл дэх дутуу, алдаатай, нийцтэй бус байдлыг илрүүлэх; - судалгааны арга зүйн мэдлэгтэй байх, тоон судалгаанд үндэслэн харьцуулалт, шинжилгээ хийх; - тулгамдсан асуудалд дүн шинжилгээ хийж, нөхцөл байдал, хувилбарыг тодорхойлох чадвартай байх; - бусад.
	Асуудал шийдвэрлэх	- Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн албаны тухай хууль, Авлигын эсрэг хууль, бусад хуулийг чандлан баримталж үндэсний язгуур эрх ашиг сонирхолд захирагдан ард түмэндээ үйлчилж төрд үнэнчээр зүтгэх; - албан тушаалын чиг үүргийн хүрээнд шийдлийн хувилбарыг боловсруулж, хариуцах; - асуудал шийдвэрлэх эдийн засаг, хууль зүйн үндэслэлийг боловсруулах; - удирдлагын өгсөн чиглэлийн дагуу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх тодорхой арга хэмжээг зохион байгуулах; - хууль тогтоомж, тогтоол шийдвэр, бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн тайлан, мэдээлэлтэй холбогдсон асуудлаар судалгаа хийж, дүнг хариуцах; - бусад.
	Багаар ажиллах	- Өөрийн мэдлэг чадвар, өөрт байгаа мэдээллийг баг хамт олонтой хуваалцаж хамтран ажиллах; - бусадтай харилцан итгэл төрүүлэхүйц ажил хэрэгч, нээлттэй харилцааг бий болгох; - шинэ санаачилга, бүтээлч хандлагыг дэмжих, үр дүнтэй өөрчлөлт, шинэтгэлийг дэмжин хэрэгжүүлдэг байх; - багаар ажиллах, багийн ажлын амжилтыг үнэлэх, дэмжих, үүрэг хариуцлага хүлээх чадвартай байх; - ажил хэргийн хувьд бүтээлч, санаачилгатай ажиллах, хөрвөх чадвартай байх; - өргөн цар хүрээтэй сэтгэж, үлгэрлэн манлайлдаг байх; - ёс зүй, хувийн зохион байгуулалт, цаг ашиглалтын хувьд бусдыг үлгэрлэн манлайлах; - бусад.
	Бусад ур чадвар	- Газар зүйн мэдээллийн системийн програм хангамжийг эзэмшсэн байх; - хүний эрхийн стандартуудыг хэрэгжүүлэх; - англи хэл эсхүл, бусад гадаад хэлээр албан тушаалын чиг үүрэгт хамаарах мэдээллийн эх сурвалжийг ашиглах; - кирилл болон үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх чадвартай байх; - компьютерын хэрэглээний программ, мэдээллийн дэвшилтэт технологи ашиглах, мэдээллийг шуурхай хүргэх; - албан ажлын чиг үүргийнхээ дагуу зөвлөгөө мэдээллээр хангаж ажиллах чадвартай байх.



IV.АЛБАН ТУШААЛТНЫ ХАРИЛЦАХ СУБЪЕКТ

Албан тушаалыг шууд харьяалан удирдах албан тушаалын нэр:

Геодези, зураг зүйн хэлтсийн дарга.

Албан тушаалд шууд харьяалан удирдуулах албан тушаалын нэр, тоо:

Бусад харилцах субъект:

- Төрийн болон нутгийн захиргааны байгууллагын хэлтэс, орон нутгийн харьяа газар, хэлтэс;
- Төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, төсөл хөтөлбөрийн холбогдох албан тушаалтан;
- Иргэн, хуулийн этгээд, мэргэжлийн байгууллага.

V.АЛБАН ТУШААЛЫН ТОДОРХОЙЛОЛТЫН БАТАЛГААЖУУЛАЛТ

Албан тушаалын тодорхойлолт боловсруулсан:

Албан тушаалын тодорхойлолтыг хянаж, батлах зөвшөөрөл олгосон байгууллагын шийдвэр:

Албан тушаал:

АЖЛЫН ХЭСГИЙН АХЛАГЧ,

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ТӨРИЙН ЗАХИРГАА, УДИРДАЛГЫН ГАЗРЫН ДАРГА

..... Б.САНДУЙЖАВ

2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр

Байгууллагын нэр:

ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

Шийдвэрийн огноо:

23 08 22

Дугаар:

365

Албан тушаалын тодорхойлолтыг баталсан:

Байгууллагын нэр:

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗАР

Шийдвэрийн огноо:

2023.08.28

Дугаар:

(тамга/тэмдэг)

ГАЗАР ЗОХИОН БАЙГУУЛАЛТ, ГЕОДЕЗИ, ЗУРАГ ЗҮЙН ГАЗРЫН ДАРГА

2023 оны 08 дугаар сарын 28-ны өдөр

